
МЭДЭЭ · 2026 оны 3-р сарын 18

ЭМГЭНЭЛ



ЭМГЭНЭЛ



БАТ-ОЧИРЫН ЦЭРЭНБАЛТАВ
(1953 - 2026)

Улсын ерөнхий прокурорын орлогч агсан, Монгол Улсын Гавьяат хуульч Бат-Очирын Цэрэнбалтав нь таалал төгсөж, бидэнд нөхөж баршгүй гарз тохиолоо.

Б.Цэрэнбалтав нь 1953 онд Сүхбаатар аймгийн Баяндэлгэр суманд төрж, 1975 онд Монгол Улсын Их Сургуулийн хуулийн ангийг төгссөн, Оросын Холбооны Улсын Аюулгүй байдал, Батлан хамгаалах хэв журмын академийн профессор цолтой.

Тэрээр 1975 онд Улаанбаатар хотын прокурорын газрын Мөрдөн байцаах хэлтсийн прокуроороор томилогдон хөдөлмөрийн гараагаа эхлүүлж, Улсын ерөнхий прокурорын газар, Дорнод, Сүхбаатар аймгийн прокурорын газар, Нийслэлийн Баянзүрх дүүргийн прокурорын газарт ажиллаж байгаад, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 1999 онд Улсын ерөнхий прокурорын орлогчоор томилогдон, Төрийн хууль цаазын шадар зөвлөх зэрэг дэвтэй, 2010 оныг хүртэл ажилласан билээ.

Б.Цэрэнбалтав нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөлийн гишүүн, Улсын дээд шүүхийн сахилгын хорооны гишүүнээр ажилласны зэрэгцээ Терроризмын эсрэг Монголын холбоог үүсгэн байгуулахад оролцож, удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байсан туршлагатай, нэр хүндтэй хуульч байсан.

Монголын Прокуроруудын Холбооны ерөнхийлөгчөөр ажиллаж, Олон Улсын Прокурорын Холбоонд анх элсүүлэх ажлыг зохион байгуулснаар Прокурорын байгууллагын нэгэн түүхэн хуудсыг нээсэн юм.

Б.Цэрэнбалтав нь улсын хэмжээний мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих ажлыг эрхлэн гүйцэтгэж, удирдан зохион байгуулж, олон онц ноцтой хэргийг хянан шийдвэрлэх, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Прокурорын байгууллагын тухай хуулийг боловсруулах, Прокурорын байгууллагыг төлөвшүүлэх, шинэтгэлийг гүнзгийрүүлэх, хууль эрх зүйн тогтолцоог сайжруулах үйлсэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан.

Тэрээр “Прокурор хүний эрхэм чанар бол хүнлэг сэтгэлтэй, аливаа асуудалд тэвчээртэй хандаж чаддаг, шударга үйлстэй, үнэн үгтэй байх явдал юм” гэсэн сургаал үгийг залуу, хойч үедээ үлдээжээ.

Б.Цэрэнбалтав нь эрх зүйн онол, практикийн хувьд маргаантай асуудлыг мэргэжлийн өндөр түвшинд задлан шинжилж, дүгнэлт хийж, хэрэг хянан шийдвэрлэх болон удирдан зохион байгуулах ажлын өндөр туршлагатай манай тэргүүний прокурор байлаа.

Гэмт хэрэгтэй тэмцэх, хүний эрхийг хамгаалах, шударга ёсыг тогтооход оруулсан түүний хувь нэмрийг Монгол Улсын төр засгаас өндрөөр үнэлж, Монгол Улсын Гавьяат хуульч цол тэмдэг, Сүхбаатарын одон, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, Алтан гадас одонгоор шагнажээ.

Түүний төлөв даруу, элэгсэг дотно тусч дүр төрх, шударга, зарчимч байдал, мэргэжлийн өндөр ур чадвар, Прокурорын байгууллагыг хөгжүүлэхэд оруулсан үнэтэй хувь нэмэр нь бидний сэтгэл зүрхэнд үүрд хоногшин үлдэх болно.

Талийгаачийн гэр бүл, үр хүүхэд, төрөл төрөгсдөд
гүн эмгэнэл илэрхийлье.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/652